



*The AMERICAN CHAMBER of Commerce in Mongolia*

**Хэвлэлийн мэдээ**  
10.06.2019

**Холбоо барих**  
+976 9511 7771

## **АмЧам Монгол “АНУ руу шууд нислэг хийх боломж, шийдэл” сэдвийн хүрээнд цуврал арга хэмжээ амжилттай зохион байгууллаа**

УЛААНБААТАР, Монгол Улс- Монгол дахь Америкийн худалдааны танхим (АмЧам) нь АНУ-ын Wicks Group-тэй хамтран 2019 оны 6-р сарын 3-наас 7-ны хооронд “АНУ руу шууд нислэг хийх боломж, шийдэл” сэдвийн хүрээнд цуврал арга хэмжээ амжилттай зохион байгууллаа.

Цуврал арга хэмжээний хүрээнд АНУ руу шууд нислэг хийхэд шаардлагатай АНУ-ын Засгийн газар болон иргэний нисэхийн байгууллагын холбогдох зөвшөөрлүүдийг авах үйл явц, боломж, шийдлийн талаар Зам, тээврийн хөгжлийн яам, ИНЕГ, МИАТ ХК-ийн удирдлагууд болон Аэро Монголиа, Изнис, Туркиш эйрлайнс, Хүннү эйр зэрэг агаарын тээврийн компанийн төлөөлөлтэй уулзаж илэн далангуй санал солилцов. Мөн шинэ нисэх буудалтай танилцаж Монгол Улсын агаарын тээврийн салбарын хөгжлийн ирээдүйн талаар тодорхой ойлголттой болсон юм.

Арга хэмжээний хүрээнд дугуй ширээний ярилцлага зохион байгуулж хоёр орны хооронд шууд нислэг үйлдэхтэй холбоотой боломж, даван шийдэх ёстой асуудлын талаар дэлгэрэнгүй ярилцав. Дугуй ширээний ярилцлагад АНУ-ын элчин сайдын яамны эдийн засаг, худалдааны хэлтсийн дарга Бэнжамин Ли Роё, Wicks группын Олон улсын үйлчилгээ хариуцсан дэд ерөнхийлөгч Ронсверт Алмонд, ахлах зөвлөх Бэрри Валентайн, болон MahoneyLiotta хуулийн фирмийн захирал Жэймс Лиотта, Зам, тээврийн хөгжлийн яамны Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Д. Мягмарсүрэн, Агаарын тээврийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Г. Батбаяр, МИАТ ХК-ийн үйлдвэрлэл эрхэлсэн тэргүүн дэд захирал Н. Ганболд нар илтгэл тавьж, салбарын холбогдох мэргэжилтнүүд санал солилцлоо.

АмЧам Монголын ТУЗ-ийн дэд дарга Гари Биондо хнэлэлцүүлгийг нээж хэлсэн үгэндээ Монгол Улсаас АНУ руу шууд нислэг үйлдэх бүрэн боломжтой гэв. Монгол Улсаас АНУ руу шууд нислэг үйлдсэнээр хоёр орны хооронд худалдаа, эдийн засаг, засгийн газар хоорондын айлчлал, бизнесийн аялал болон аялал жуучлалыг нэмэгдүүлэх онцгой ач холбогдолтой байх бөгөөд АмЧам Монголын хувьд энэхүү шууд нислэг үйлдэх боломжийг бодит ажил хэрэг болгох тал дээр АНУ-ын Wicks Group-тэй хамтран ажиллаж, гарц шийдлүүд болон дараагийн алхамуудыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх болно гэв.

Wicks Group нь АНУ-ын Вашингтон хотод төвтэй олон улсын нисэхийн салбарын зөвлөгөө өгдөг тэргүүлэгч компани бөгөөд Энэтхэг, Азербайжан болон Африкийн олон улсуудад АНУ-ын нисэхийн салбарын хууль боловсруулагчидтай хэрхэн хамтран ажиллаж, ямар арга хэмжээ авах талаар зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан арвин туршлагатай компани юм.

Wicks Group-ийн зүгээс шууд нислэг үйлдэх агаарын тээврийн зөвшөөрөл авахын тулд хангах ёстой таван үе шат бүхий шаардлагуудыг танилцуулсан юм.

Хэлэлцүүлгийн үеэр АНУ-ын ЭСЯ-ны Бэнжамин Ли Роё хэлэхдээ "Хоёр орны хооронд шууд нислэг үйлдэхийг АНУ дэмжиж байна. Монгол Улс АНУ руу шууд нислэг үйлдэх эрхийг олон үе шаттай, өндөр шалгууртай шаардлагыг хангаж байж олгох юм" гэв. Шууд нислэг үйлдэхийн тулд нэн түрүүнд АНУ-ын холбогдох яаманд зөвшөөрөл авах хүсэлтээ хүргүүлж, хүсэлтийн дагуу МИАТ-ийн техник, технологи, үйл ажилгааны аюулгүй байдалд шалгалт, аудит хийгдэх ёстой юм.

Тэргүүн дэд захирал Н.Ганболд МИАТ-ын хэрэгжүүлж буй төслүүдийг танилцуулж хэлэхдээ, "2021 он гэхэд АНУ-руу шууд нислэг үйлдэх боломжтой болно. Таван шалгуурын эхнийхийг хангасан ба дараагийн шалгууруудын бэлтгэлийг хангаж байна" гэж мэдэгдэв. "МИАТ" дээрх бүх шаардлагыг бүрэн хангах зорилготой байгаа бөгөөд энэ оны аравдугаар сард шинэ онгоц авахаар төлөвлөж байгаа гэв.

### **АмЧам Монголын тухай**

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.